

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН
АМНЫ ХӨНДИЙ, НҮД, СОНСГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.НОМИН-ийн
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Амны хөндийн эрүүл мэнд, нүүр амны тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ №1.1.1 “Эрүүл Шүд” арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)-ний хэрэгжилтийг хангах	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын хамтарсан 2024 оны 01 сарын 19- ний А/27А/25 дугаар тушаал	2024 онд үйл ажиллагааны хэрэгжилт 60% д хүрсэн байна	Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/27/А25 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөө”-г 2024-2027 онд хэрэгжүүлэхээр баталж, 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Баруун бүсийн 5 аймагт “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2024 оны 09 дүгээр сарын 10- ны өдрөөс 1 сарын хугацаатай ДЭМБ-тай хамтран зохион байгуулж 9-12 насны хүүхдүүд, багш сурган хүмүүжүүлэгч, гэр бүлийн гишүүдийг оролцуулан нийт 1000 хүүхэд хамрагдсан.	2024.10.0 7- 2024.12.0 5	100

2

					Нийслэлийн 50 болон 37-р ерөнхий боловсролын сургууль дээр 2024 оны 10-р сараас эхлэн ЖАЙКА олон улсын байгууллага, Өвсний үндэс ТББ, Чингэлтэй дүүргийн тамгын газар, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн хамтарсан төсөл хөтөлбөрийн хүрээнд бага ангийн сурагчдыг фторт уусмалаар амыг зайлуулах ажил эхэлсэн ба нийт 1900 гаран сурагчдыг долоо хоногт 1 удаагийн давтамжтайгаар зайлуулж байна. “Эрүүл шүд” төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр ерөнхий боловсролын 183 сургууль улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалт, эцэг эхчүүдийн дэмжлэг (53.3 сая төгрөг)-ээр шүд угаах цэг байгуулсан байна. Мөн ерөнхий боловсролын 186 сургууль шүд угаах цагийн зохицуулалт хийж бага ангийн суралцагчид их завсарлагааны үеэр шүд угаах боломжтой болсон. Ерөнхий боловсролын сургуулийн 13.2 хувь буюу 123 сургууль улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, төрийн бус байгууллагын санхүүжилтээр амны хөндийн эрүүл ахуйн үзүүлэн, макет зэрэг		
--	--	--	--	--	--	--	--

22

					хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Шүд, амны хөндийн эрүүл мэндийн сургалтад 21 аймаг, 9 дүүргийн 331,459 суралцагч хамрагдсан бөгөөд 315,735 суралцагч шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсанаас 54,880 суралцагчийн шүдийг эрүүлжүүлж, 20,429 суралцагч сургуулийн орчинд шүдээ угааж хэвшсэн байна. Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих сургалт, үйл ажиллагааг 527 сургууль зохион байгуулж 136558 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулсан.		
2.	Арга хэмжээ №1.1.2 Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны заавар батлуулах	Батлагдсан журам	Зааврын төсөл 70%-тай	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна	ЭМ-ийн сайдын 2024 оны 10-р сарын 31-ний өдрийн А433 тушаалаар Нүүр ам судлалын салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлагдсан. 2024 оны 11-р сарын 13-нд салбар хурал НАТҮЧАБ-ын тушаалын төсөлтэй танилцаж, хэлэлцэн ба Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл 2024 оны 11-р сарын 13-ны өдрийн ш/01 дугаартай албан бичгийг НЭМБГ-т хүргүүлсэн ба тус бичигт ЭМ сайдын 2022 оны 10-р сарын 12-ны өдрийн А/493 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн байгуулах тухай саналын дагуу ажлын хэсгийг ЭМ сайдын тушаалаар шинэчлэн батлуулсан.	2024.11.13-2024.12.05	30

3.	Арга хэмжээ №1.1.3 Шүд угаалтын олимпиад зохион байгуулах	Зохион байгуулсан олимпиадын оролцсон хүүхдийн тоо	2023 онд 2 удаа шүд угаалтын олимпиад зохион байгуулагдсан	Шүд угаалтын олимпиадыг 5 аймгийн 1000 хүүхэд хамруулсан байна.	Баруун бүсийн 5 аймагт "Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 1 сарын хугацаатай ДЭМБ-тай хамтран зохион байгуулж 9-12 насны хүүхдүүд, багш сурган хүмүүжүүлэгч, гэр бүлийн гишүүдийг оролцуулан нийт 1000 хүүхэд хамрагдсан.	2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 1 сарын хугацаатай	100
4	Арга хэмжээ №1.1.4 Нүүр амны эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Батлагдсан заавар	-	Зааврыг батлуулсан байна. Сургалтыг эмч, эмчийн туслахад орсон байна	Нийслэлийн хэмжээнд 128 эмч, 128 эмчийн туслахыг чадавхжуулах сургалтад 2024 оны 9-р сарын 27-ны өдөр хамруулан 3 ээлжээр зохион байгуулсан. Сургалтын агуулгад эрт илрүүлэг хийх аргачлал, эрүүл ахуйн үзүүлэлтийг үнэлэх, амны хөндийд түгээмэл тохиолдох өвчлөлийг бүртгэх, ЕБС-ийн эрт илрүүлгийн үзлэгийг хийхэд анхаарах зүйлийг	2024.09.27	100
5	Арга хэмжээ №1.1.5 Амны хөндийн эмгэгээс урьдчилан сэргийлэх үзлэг, шүдийг фторжуулах ажлыг нийслэлийн ЕБС-ийн 1 дүгээр ангийн сурагчдад зохион байгуулсан байна	Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо	-	Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийслэлийн ЕБС-ийн 1 дүгээр ангийн хүүхдүүдийг хамруулсан байна.	Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413/А151 дугаар хамтарсан тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийх арга хэмжээ"-ний тушаал батлагдсан ба нийслэлийн хэмжээнд 21,272 хүүхдэд фторт түрхлэгийг түрхэж эрдэсжүүлэлтэд хамруулав.	2024.10.07-2024.12.05	100
6	Арга хэмжээ №1.1.6	Арга хэмжээний тоо		Хүүхдэд зориулсан	Азийн хөгжлийн банкны "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл	2024.11.14-	100

23

	Амны хөндийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах		-	мэдээлэл хүргэх контент бэлдсэн байна.	мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн хүрээнд "Номадик контент ХХК"-тай хамтран эрүүл шүдний ач холбогдол, шүд угаах, эмчид үзүүлэхийн ач холбогдлын тухай бичлэгийг хийлгэж бэлтгэл ажил 70%-тай байна.	2024.12.05	
7	Арга хэмжээ №1.1.7 2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн 6 настуудад нүд, шүдний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах журам эсхүл удирдамж батлуулах	ЭМС, БС-ын хамтарсан тушаал	-	Батлагдсан журам/удирдам жийн дагуу эрт илрүүлгийн үзлэг хийгдэнэ	Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413/А151 дугаар хамтарсан тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийх арга хэмжээ"-ний тушаал батлагдсан.	2024.09.27-2024.12.05	100
8	Арга хэмжээ №1.1.8 2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн 6 настуудад нүд, шүдний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах	Нийслэлийн 275 ЕБС-ийн 36969 сурагчийг хамруулсан байна	-	Нийслэлийн 275 ЕБС-ийн 36969 сурагчийг хамруулж, 2025 онд хөдөө орон нутагт хийгдэх бэлтгэл ажлыг хангана	Нийслэлийн хэмжээнд шүдний эрт илрүүлгийн үзлэгт 21,272 сурагч, нүдний үзлэгт 14,017 сурагч хамрагдсан ба нийт хамрагдвал зохих сурагчдаас 63.56%-ийг хамруулаад байна.	2024.10.07-2024.12.05	100
Зорилт 2. "Эрүүл ахуй, тархвар судлалын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт, удирдлага зохион байгуулалтын зорилтын хүрээнд"							
1.	Арга хэмжээ 1.2.1 Эрүүл ахуй, тархвар судлаачдын зөвлөгөөн зохион байгуулах	Зохион байгуулагдсан зөвлөгөөн	2016 онд гуравдугаар зөвлөгөөн зохион байгуулагдсан	Эрүүл ахуйч, тархвар судлаачдын үндэсний дөрөв дүгээр зөвлөгөөнийг зохион	2024 оны 12 дугаар сарын 04-05 өдрүүдэд "ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨХ ШИЙДЭЛ" ЭРҮҮЛ АХУЙЧ, ТАРХВАР СУДЛААЧДЫН IV ЗӨВЛӨГӨӨН"-ийг зохион байгуулсан ба нийслэл, хөдөө	2024.12.04-05	100

				байгуулсан байх	орон нутгаас нийт 125 хүн хамрагдсан.		
--	--	--	--	--------------------	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			3	4	5	6	7
1.	Арга хэмжээ №2.1. Ажил үүрэгтэй холбоотой мэдлэг, мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	-	Богино хугацааны сургалтад сурсан байна	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн чиглүүлэх богино хугацааны сургалтад улсын төсвийн санхүүжилтээр суралцана.	2024.12.05	100
2.	Арга хэмжээ №2.2. Able хэрэглээний тухай цахим сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	-	Цахим сургалтад хамрагдах	Able хэрэглээний цахим сургалтад хамрагдаж анхан шатны мэдлэгийг авав.	2024.10 сар	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт бус өвчний амны хөндий, нүд, сонсголын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Номин /  /

2024.12.05

8